



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	12
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал.....	14
3.1	Хөрөнгөтэй холбоотой.....	14
3.2	Нөхөн сэргээлтийн баталгаа данстай холбоотой.....	14
3.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.4	Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагатай холбоотой.....	15
4	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан.....	16
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5	Хавсралт.....	21
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21
5.2	Албан шаардлага.....	28
5.3	Төлбөрийн акт.....	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ
ТАНАА

2019. Оч. 25 № 857
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Н.Цэрэнбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг арилгах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, авлага, өр төлбөр, хөрөнгөтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

БОАЖС 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/2149 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэж, холбогдох нотлох баримтыг баталгаажуулсан болно.



Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

БОАЖЯ нь "Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино" гэсэн эрхэм зорилготой ажилласан байна.

Үйл ажиллагаа:

БОАЖЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх, энэ чиглэлд Засгийн газрын манлайллыг хангах;
- Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээрх хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болох захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан чиглүүлэх;
- Яам, салбарын албан хаагч, ажиллагсад байгаль хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх шинжлэх ухааны ололт, олон улсын тэргүүний арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах;

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын удирдлага Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамны хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Тус санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

БОАЖЯ санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” програм хангамж ашигласан байна.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

БОАЖЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тайлант онд 38 байгууллага, 2 төслийн санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар нийт 242.8 сая төгрөгийн зөрчилд 341 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

Нийт илэрсэн зөрчлийн 49.5 хувь буюу 120.8 сая төгрөг нь цалин болон нэмэгдэл урамшууллыг илүү, дутуу тооцсонтой холбоотой зөрчил байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны нийт зардал 106,149.4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 2,123.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Материаллаг байдлын суурийг тооцохдоо үйл ажиллагааны болон хөрөнгийн зардлууд нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага тул нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонголоо.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа 96 байгууллага, нэгжийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулахаас 72 байгууллага, нэгж аудитад хамрагдсан байна.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр, тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1			
2	Төсвийн шууд захирагч	64	4	12	-
3	Засгийн газрын тусгай сан	1			
4	Төсөл хөтөлбөрийн нэгж	4	-	-	5
5	Төрийн өмчит аж ахуйн нэгж	2	1	-	1
6	Төсвийн ерөнхийлөн захирагч	1		-	-
	Дүн	73	5	12	6

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторын А/156 дугаар тушаал

Аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн 72 санхүүгийн тайлангаас “Зөрчилгүй” 69, “Хязгаарлалттай” 3 санал дүгнэлт авсан байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 13,723.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийн 88.3 хувь буюу 12,129.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.7 хувь буюу 366.0 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 1.9 хувь буюу 253.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 7.1 хувь буюу 974.2 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төсвийн шууд захирагчийн 229.4 сая, төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2,394.6 сая, төрийн өмчит аж ахуйн нэгжийн 276.4 сая, Засгийн газрын тусгай газрын сангийн 0.9 сая, төвлөрүүлэн захирагчийн 8,864.9 сая, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 363.3 сая, нийт 12,129.5 сая төгрөгийн 44 алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:



Хүснэгт 2 (Алдаа, зөрчил түүний шийдвэрлэлт, сая төгрөгөөр)

№	Байгууллагын ангилал	Залруулаа-гүй алдаа, зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн ерөнхийлөн захирагч	7	651.5	-	-	2	137.1	3	514.4	2	-
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	3	6.5					2	6.5	1	-
3	Засгийн газрын тусгай сан	2	33.1					2	33.1		
4	Төсвийн шууд захирагч	97	751.7	26	361.7	19	47.2	52	342.8		
5	Төрийн өмчит аж ахуйн нэгж	5	77.0	1	4.3	1	-	3	72.7		
6	Төсөл хөтөлбөрийн нэгж	17	73.7			3	73.7	14			
	Дүн	131	1,593.5	27	366.0	25	258.0	76	969.5	3	-

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Цаг уур орчны шинжилгээний газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 8,864.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 6.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж, тайлагнаагүй;
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт 8,864.9 сая төгрөгийг цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүн дансанд тайлагнасныг аудитын явцад залруулсан.
- Тайлант онд эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 2.8 сая төгрөгөөр тооцоо нийлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй байна. Мөн баярын өдрүүдээр ажилласан цагийн тооцоог олгосон цалингийн нэмэгдэлтэй тулган шалгахад шинэ жилийн баярын өдрөөр ажилласан 103 цагийн тооцоо гарсан боловч 111 цагаар буюу 8 цаг илүү бодож нэмэгдэл цалин олгосон.
- Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх пуужингийн зарцуулалт 9 пуужин буюу 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй. Пуужингийн зарцуулалтыг харвалтын тайлантай тулган шалгахад 9 пуужин харвасан акт дутуу байгаа нь Улаанбаатар хотын экспедицийн харвасан 6 пуужингийн акт дутуу, зарим аймгууд шаардлага хангахгүй пуужинг үлдэгдлээр тоолдог, эсвэл зарцуулсанд тооцдог зэргээс 3 пуужингийн зөрүүтэй илэрхийлэгдсэнд зөвлөмж өгсөн байна.

Засгийн газрын тусгай сан:

Байгаль орчин, уур амьсгалын санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 0.9 сая төгрөгийн 1 алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 6.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

- Санхүүгийн програм хангамжийг бүртгэлд авахдаа аж ахуйн материалд орлогоор бүртгэсэнийг залруулсан.
- Тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй өр төлбөр нь 2014 оноос он дамжин бүртгэгдэж байгаа ба тайлант онд 12.8 сая төгрөгийг барагдуулж 279.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй

тайлагнасан байна. Өр төлбөрийн үлдэгдэлтэй харилцагч нарт тооцоо нийлэх хүсэлт явуулснаас 33.1 сая төгрөгийн авлагатай 5 харилцагч тус сантай тооцооны үлдэгдэлгүй талаар албан бичиг ирүүлсэн.

- Эко халаагуур нийлүүлэх тухай 2018 оны 18/350 дугаартай гэрээгээр Эрүүл мэнд-Интернейшнл байгууллагаас 2 загварын цахилгаан халаагуур нийт 622 ш хүлээн авахаас одоогийн байдлаар 500 ш хүлээн авч 122 ш эко цахилгаан халаагуур дутуу байна. Мөн тайлант хугацаанд Баянзүрх дүүрэг, Баянгол дүүргийн 200 оршин суугчидтай гэрээ байгуулж эко халаагуур олгосныг тулган шалгахад баримт материал дутуу 2 хүн байна.

Төсвийн шууд захирагчид:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан 64 байгууллагаас “Хязгаарлалттай” 2, “Зөрчилгүй” 62 санал дүгнэлт авсан байна. Аудитаар нийт 981.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 229.4 сая төгрөгийн 30 алдаа, зөрчлийг залруулж, 361.7 сая төгрөгийн 26 төлбөрийн акт, 47.2 сая төгрөгийн 19 албан шаардлага, 342.8 сая төгрөгийн 52 зөвлөмж хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй дараах нийтлэг алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэгдсэн гэрээт ажлууд гэрээний хугацаанд хийгдээгүй, ажил нь зогссон, ажил хүлээн авсан актгүй зэргээс шалтгаалан он дамжин бүртгэгдсэн;
- Хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан;
- Амралтын мөнгө олгохдоо хоол унааны мөнгө илүү тооцож олгосон;
- Гадаад томилолтын удирдамжид заасны дагуу томилолтын тайлан, илтгэх хуудас бичээгүй, үр дүнг тайлагнаагүй, холбогдох анхан шатны баримт бүрдүүлээгүй байна;
- Худалдан авсан хангамж, бараа материал, тогтмол зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн;
- Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын дагуу кассын тайланг гаргаж ажиллаагүй, касс дахь мөнгөний үлдэгдлийн тооллого тооцоо хийгээгүй;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт түрээсийн орлого төвлөрүүлээгүй зэрэг алдаа зөрчлүүд илэрсэн байна.

Төсөл хөтөлбөрийн нэгжүүд:

Төсөл хөтөлбөрүүдэд хийсэн аудитаар 2,394.6 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 117,1 сая төгрөгийн 3 албан шаардлага, 14 зөвлөмж өгсөн байна.

Төсөл хөтөлбөрүүдэд дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төслийн тусгай гэрээнд заасан орон тоог мөрддөггүй, гэрээт ажилтан ажиллуулан цалингийн зардлыг нэмэгдүүлсэн;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан бусдаас түрээсэлдэг байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байх гэж заасныг хэрэгжүүлдэггүй, ашиглалтын зардлыг түрээсийн зардалд оруулж тайлагнадаг;
- Төслийн 2018 оны төсөвт гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад гадаад томилолтын зардал гарсан ба томилолтын үр дүнг үнэлж дүгнээгүй, төслийн үндсэн зорилготой хамаатай эсэх нь тодорхойгүй;
- Хөрөнгө оруулалт, худалдан авалт болон үйл ажиллагааны зардлын төсвийг Сангийн ямаар батлуулаагүй;
- Бараа материалыг бүртгэлд тусгадаагүй зэрэг алдаа, зөрчлүүд байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгж:



Аудитад хамрагдсан 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд 276.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2 зөвлөмж өгсөн байна.

- Усны салбарын 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхээр бусад байгууллагаас авсан 142.5 сая төгрөгийн хандив тусламжийг орлогоор бүртгэсэн болон ойн арга хэмжээг тэмдэглэхэд гарсан 133.9 сая төгрөгийн зардлыг татвар ногдох зардлаас хасагдах зардлаар бүртгэсэнийг залруулсан.
- Бэлэн мөнгөний нярав кассын бүртгэлийг гараар хөтөлдөггүй, өдөр бүр үлдэгдлээр бодитоор гаргахгүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт зааврыг мөрдөж ажиллах" журамд нийцэхгүй;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байгаад зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хугацаанд Аялал жуулчлалын хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлсэн.

- БОАЖЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Казиногийн тухай хуулийн төсөл боловсруулах 43.0 сая төгрөгийн гэрээт ажлын хугацаа 2018 оны 10 дугаар сарын 18-нд дууссан боловч ажлын гүйцэтгэлийн тайлан бичээгүй, гэрээ дүгнэсэн актгүй тул үлдэгдэл санхүүжилт 4.3 сая төгрөгийг олгоогүй байна.

Шийдэл: Гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 4.3 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл, Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаа, Увс аймгийн “Цаг уур, орчны шинжилгээний төв” нь 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлсэн.

2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 99.7 сая төгрөгөөр дутуу, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн дүн 232.9 сая төгрөгөөр зөрүүтэй, хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд техник хяналтын дансаар дамжуулан зарцуулсан 30.7 сая төгрөгийг эргэлтийн бусад хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Шийдэл: Аудитын явцад 363.3 сая төгрөгийн 3 алдааг залруулсан.

Асуудал 2: Гадаад томилолтын зардал

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 3 байгууллагад нийт 132.4 сая төгрөгийн гадаад томилолтын зардалтай холбоотой зөрчил илэрсэн байна. Үүнд:

- “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-аас БОАЖС-ын тушаалаар гадаад орнуудад томилолтоор ажиллах 46.0 сая төгрөг баталсан боловч томилолтоор ажиллах хугацаа тодорхойгүй, тийзний төлбөрийг урьдчилан шилжүүлсэн, гадаад томилолтоор ажилласан тайлан, илтгэх хуудас, анхан шатны баримтгүй;
- БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Аялал жуулчлалын хөгжлийн төвд шилжиж ирсэн 43.0 сая төгрөгийн Европын зарим орнуудад “Казиногийн тухай хууль” боловсруулахтай холбоотойгоор судалгаа хийх томилолтын тайлан, илтгэх хуудасгүй,
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөлд гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад 43.4 сая төгрөгийн томилолтын зардал гарсан боловч томилолтын үр дүнг үнэлж дүгнээгүй, төслийн зорилготой хамаатай эсэх нь тодорхойгүй байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлсэн.

Асуудал 3: Дотоод аудит

Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод ажил, бичиг хэрэг, нярваар ажиллаж байсан ажилтныг ажлаас буруу халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, төсвөөс 4.7 сая төгрөгийн нөхөн олговор олгосон зөрчил илэрсэн байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант оны эцэст буюу төрийн сангийн гүйлгээ хааснаас хойш тус яамны Хөрөнгө оруулалтын данс болон Техник хяналтын данс хооронд 1,609.2 сая төгрөгийг шилжүүлж гүйлгээ хийсэн байна. Мөн Чингэлтэй дүүргийн Соёл, спорт, амралт, аялал жуулчлалын барилгын санхүүжилт 2,686.2 сая төгрөгийг Хас банкны баталгаагаар “Эко тогтол” ХХК руу шилжүүлсэн зэрэг гүйлгээ гарсан байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

БОАЖС-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2018 онд 6 хөтөлбөр, 16 арга хэмжээнд зориулан 88,160.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 147.5 сая төгрөг буюу 49.9 хувиар давсан, зардлын нийт гүйцэтгэл 82,241.5 сая төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр, Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцлийг сайжруулах төсөл, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн гүйцэтгэл дутуу гарсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар нийт 17,949.9 сая төгрөгийн орлого, 16,541.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

БОАЖС Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

БОАЖЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төвлөрүүлэн захирагчийн 1, төсөл хөтөлбөрийн 5, төсвийн шууд захирагчийн 82, нийт 89 байгууллагыг хамруулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дүгнэлт зөвлөмж хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 18 төрлийн 42 мэдээг Шилэн дансны цахим хуудсанд оруулах шаардлагатайгаас хугацаа хоцорсон 11, мэдээлэл оруулах хугацаа болоогүй 2, огт оруулаагүй 6 мэдээлэл, Төсвийн шууд захирагчдын 18-20 төрлийн 1778 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 1180, хугацаа хоцорсон 143, хугацаа болоогүй 356, огт оруулаагүй 99 мэдээлэл байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 84.1 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй мэдээллээ оруулаагүй, улирлын тайланг дараа сарын 15-наас өмнө цахимаар ирүүлээгүй, мэдээллээ дутуу оруулсан 22 байгууллага байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 94.9 хувьтай байна.

Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай" А/160 дугаар тушаалаар аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодогч нарын чадавхыг сайжруулах, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын зөвлөмж, хууль, дүрэм, журам, цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах сургалтыг зохион байгуулж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгөтэй холбоотой

3.1.1 Илрүүлэлт

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй 526.1 сая төгрөгийн хөрөнгийн 398.6 сая төгрөгийн хөрөнгө нь Хими, химийн технологийн хүрээлэнд 2017 оноос ашиглагдаж байгаа боловч балансаас балансад шилжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл

Хөрөнгө дутагдах, үнэгүйдэх, холбогдох хууль тогтоомжийн заалт хэрэгжихгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн.

3.2 Нөхөн сэргээлтийн баталгаа данстай холбоотой

3.2.1 Илрүүлэлт

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны үлдэгдэл 14,037.2 сая төгрөг байгаа боловч төсөл хэрэгжүүлэгч бүрээр төвлөрүүлсэн орлого, буцаан олгосон мөнгөн хөрөнгийн нэгдсэн бүртгэл, мэдээ гаргаагүй байна. Мөн төсөл хэрэгжүүлэгчийн төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тайлагнах батлагдсан маяггүй, Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг хянаж баримтжуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл

Хяналт алдагдах, байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомжийн заалт хэрэгжихгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д “.... сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн.

3.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

3.3.1 Илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 18 төрлийн 42 мэдээг Шилэн дансны цахим хуудсанд оруулах шаардлагатайгаас хугацаа хоцорсон 11, мэдээлэл оруулах хугацаа болоогүй 2, огт оруулаагүй 6 мэдээлэл, Төсвийн шууд захирагчдын 18-20 төрлийн 1778 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 1180, хугацаа хоцорсон 143, хугацаа болоогүй 356, огт оруулаагүй 99 мэдээлэл байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 84.1 хувьтай байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй мэдээллээ оруулаагүй, улирлын тайланг дараа сарын 15-наас өмнө цахимаар ирүүлээгүй, мэдээллээ дутуу оруулсан 22 байгууллага байна.

3.3.2 Эрсдэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн.

3.4 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагатай холбоотой

3.4.1 Илрүүлэлт

Аудитын түүвэрт хамрагдсан Аялал жуулчлалын хөгжлийн төв нь БОАЖЯ-аас авах 6.9 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайландаа тусгаагүй, 65.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.4.2 Эрсдэл

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.

3.4.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн, хариу тайлбар

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,227,382.8	45,893,319.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,729,450.8	16,283,397.1
33	АВЛАГА	1,249,671.6	1,800,803.2
34	УРЬДЧИЛГАА	8,729,821.0	8,435,208.1
35	БАРАА МАТЕРИАЛ	7,960,291.4	8,283,749.2
36	НӨӨЦИЙН БАРАА	1,558,148.0	-
	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	11,090,162.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,286,519.8	60,644,065.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,286,519.8	60,644,065.3
392	Биет хөрөнгө	39,115,551.7	43,561,341.4
393	Биет бус хөрөнгө	170,968.1	17,082,723.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>75,513,902.6</u>	<u>106,537,384.8</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,013,233.1	15,400,070.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,013,233.1	15,400,070.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	61,500,669.5	91,137,314.4
51	Засгийн газрын хувь оролцоо	61,500,669.5	91,137,314.4
512	Хуримтлагдсан үр дүн	24,450,710.4	32,895,462.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,139,665.6	6,644,142.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>75,513,902.6</u>	<u>106,537,384.8</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	91,088,684.8	99,667,944.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,875,280.4	18,256,720.2
120	Нийтлэг татварын бус орлого	12,160,516.0	9,412,111.1
122	Тусламжийн орлого	14,714,764.3	8,844,609.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,213,404.4	81,411,224.2
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,922,299.7	84,754,780.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,363,960.4	80,898,491.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,133,988.1	72,064,839.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,373,210.2	26,205,589.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,856,421.3	3,124,231.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,480,959.1	1,514,296.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,798,540.4	1,888,529.9
2105	Нормативт зардал	292,712.0	60,702.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,952,129.3	773,793.0
2107	Томилолт, зочны зардал	848,245.0	790,572.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,606,082.7	25,840,883.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,925,688.2	11,866,240.1
212	ТАТААС	-	3,094,912.5
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	3,094,912.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,229,972.3	5,738,739.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,558,339.3	3,856,289.2
2200	Дотоод эх үүсвэрээр	11,558,339.3	3,856,289.2
